

## ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	2
ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БҮЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	5
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	6
ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	10
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	11
ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	14
ДОЛОО. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	14
НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	15
ЕС. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	15
АРАВ. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	15
АРВАННЭГ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	17
АРВАНХОЁР. ОРЧНЫХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР <b>Error! Bookmark not defined.</b>	
АРВАНГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	18
АРВАНДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БУСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	20



Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших MV-00168 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй  
алтны шороон ордыг ашиглах төслийн  
2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

<b>ТӨСЛИЙН НЭР:</b>	“Толгойт-2 ” алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах төсөл
<b>ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН НЭР: УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ: РЕГИСТРИЙН ДУГААР:</b>	“Ди Зэт Энд Ай ” ХХК 9011009051 2570769
<b>АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР:</b>	MV-00168 /202.34 га/
<b>ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХАЯГ:</b>	Улаанбаатар хот , Сүхбаатар дүүрэг 1-р хороо Энхтайваны өргөн чөлөө Монгол даатгал ХХК-н УБ хотын салбар 203 тоот 99036232
<b>ТӨСЛИЙН БАЙРШИЛ:</b>	Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны нутагт орших бөгөөд Бугант тосгоны төвөөс зүүн урагш 15 км, Ерөө сумын төвөөс зүүн хойш 80 км, Улаанбаатар хотоос баруун хойш 450 км зайдай.

**Ордын байршил, засаг захиргааны харьяалал:** Тус орд газар нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Дархан хотоос зүүн хойш 170 км, Сүхбаатар хотоос зүүн урагш 200 км, Ерөө сумын төвөөс зүүн урагш 80 км, Бугант суурингаас зүүн хойш 15 км-д байрлана. ЯМВ-0168 тоот ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн дагуу ашиглалт явуулах бөгөөд ашиглалтын тусгай зөвшөөрлийн газар зүйн солбицол нь:

- |                                   |                                    |
|-----------------------------------|------------------------------------|
| 1. 107° 23' 52" 49° 29' 15.44"    | 5. 107° 23' 5.77" 49° 29' 15.12"   |
| 2. 107° 23' 29.17" 49° 29' 15.93" | 6. 107° 22' 27.55" 49° 29' 15.9"   |
| 3. 107° 23' 29.22" 49° 29' 17.21" | 7. 107° 22' 24.47" 49° 29' 14.28"  |
| 4. 107° 23' 5.89" 49° 29' 17.7"   | 8. 107° 22' 18.03" 49° 29' 14.48"  |
| 9. 107° 22' 17.95" 49° 29' 12.53" | 10. 107° 22' 13.47" 49° 29' 12.63" |
| 11. 107° 22' 13.35" 49° 29' 9.88" | 12. 107° 22' 10.11" 49° 29' 9.95"  |


координат бүхий 202.34 га талбай юм. Монгол орны 1:100 000 байр зүйн зургийн номенклатурын М-48-95-р хавтгайд байрлана.



Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших MV-00168 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй

алтны шороон ордыг ашиглах төслийн

2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



*Зураг №1 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбайн байришил*

### **Дэд бүтэц, зам харилцаа**

Тус орд газар нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Баянгол болон Булаг голын бэлчир орчим Дархан хотоос зүүн хойш 120 км, Сүхбаатар хотоос зүүн урагш 200 км, Ерөө сумын төвөөс зүүн урагш 30 км, Бугант суурингаас баруун урагш 20 км-д байрлана.

Толгойтын алтны бүлэг ордыг ашиглах үед Бугант тосгон, эмнэлэг, сургууль, 110 кВт-ын цахилгааны өндөр хүчдэлийн шугам, автомашины сайжруулсан зам зэргийг барьж байгуулснаар дэд бүтцийн гол гол асуудлууд бүрэн шийдэгдсэн байдаг.

Уурхайд дараах дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлуудыг хийгээд байна. Үүнд: Уурхайд ажилчдын хотхон, цайны газар, амрах байр, дууш саун, оффис, амрах байр, засварын газар зэрэг барилга байгууламжууд, цахилгаан хангамж, ус хангамж, зам талбай зэрэг уурхайн дэд бүтцийг бүрэн шийдсэн. Мөн олборлолтын болон элс угаан баяжуулах цехийн тоног төхөөрөмжүүд, ажиллах хүчинээр бүрэн хангадсан.

### **Төслийн хүчин чадал**

“Ди Зэт Энд Ай” ХХК нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжих үйл ажиллагааны хүрээнд алт олборлох, баяжуулах зорилгоор ордыг ашиглахаар төлөвлөсөн. Уг төслөөс Сэлэнгэ аймгийн Ерөө сумын бүс нутагт хэрэгжүүлэх “Толгойтын алтны шороон орд” төслийн хүрээнд 2016 оны 05 дугаар сарын 11-нд боломжтой болон бодитой /В/ зэрэглэлээр 604.84 мянган.м<sup>3</sup> элс АМГ-ын Геологи судалгааны хэлтэс, ЭБМЗ-р батлуулсан. Үүнээс төлөвлөгөөт жилд мянган.м<sup>3</sup> элс олборлохоор ТЭЗҮ-д тусгагдсан байна. Толгойтыг алтны шороон үүсмэл ордод хийгдсэн хайгуулын ажлын үед олон жилийн цэвдэг илрээгүй нь ордыг ил аргаар олборлох таатай нөхцөлийг бүрдүүлж байна

### **Ил уурхайн үйл ажиллагааны тухай**

Уурхайн өдөр тутмын үйл ажиллагаа нь хөрс болон хүдэр элс тээвэрлэлт, ухаж ачих, овоолго гэсэн дэс дараатайгаар явагдана.

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших MV-00168 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй

алтны шороон ордыг ашиглах төслийн

2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Ил уурхайн 2023 оны хүчин чадал нь:** Нийт 113.7 мян.м<sup>3</sup> хөрс хуулж 125.0 мян.м<sup>3</sup> элс олборлоно.

Уурхайн нь 2023 оноос эхлэн 5 сарын 1-ээс 10 сарын 31-ны хооронд тасралтгүй ажиллах бөгөөд жилд баяр ёслол, цаг агаарын хүндэрэл, засвар зэргийг 180 хоног ажиллах ба хоногт ажиллах уурхай 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

### Уурхайд ажиллуулах техник тоног төхөөрөмж

Толгойтын алтны шороон ордын нөөцийг ил уурхайн аргаар олборлохоор төлөвлөсөн. Уурхайд ажиллуулах техник, тоног төхөөрөмжийн сонголтыг БНХАУ-ын уул уурхайд өргөн хэрэглэгдэж байгаа тоног төхөөрөмжүүдийг техникийн үзүүлэлт, үнэ, ашиглалтын гол зардал, хүчин чадал зэрэг үзүүлэлтүүдийг үндэслэн сонгосон.

Хүснэгт -1. Уурхайд ашиглах техник

Д.Д	Ашиглагдах тоног төхөөрөмж	Марк, багтаамж	Хэмжих нэгж	Тоо ширхэг
<b>Уурхайд ажиллах техник</b>				
1	Экскаватор	HUINDAI 300	Ш	3
2	Авто ачигч	LUIGONG	Ш	3
3	Автосамосвал	HOWO	Ш	7
<b>Үйлчилгээний техник</b>				
6	Усны машин	STR	Ш	1
7	Түүлшний машин	Howo	Ш	1
8	Ланд	79	Ш	1
9	STR	1	Ш	1
<b>Түрээсийн техник</b>				
10	Утгуурт ачигч	Volvo	Ш	2
<b>Нийт</b>				<b>19</b>

### Ажиллах хүчиний тухай

2023 онд уурхайн хэмжээнд нийт 62 ажилтан ажиллана. Эдгээр ажилтнууд нь вахтын системээр 2 ээлжээр 14 хоног ажиллаж 14 хоног амрах хуваарийн дагуу ажилладаг.

Хүснэгт-2. Ажилчдын задаргаа.

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга			Тайлбар
			ТЭЗҮ (тухайн жилд төлөвлөсөн)	Төлөвлөгөө Үндсэн	Туслан гүйцэтгэгч	
1	Ажилчид	a	Үндсэн	хүн	31	62
			Гэрээт	хүн		4
		б	Эрэгтэй	хүн		59
			Эмэгтэй	хүн	3	
			Гадаад	хүн		
		в	ИТА	хүн	3	4
			Оператор	хүн	8	
			Туслах	хүн	10	
			Бусад	хүн	10	
		г	Орон нутгийн	хүн	103	28
			<b>Нийт</b>		<b>62</b>	



Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших MV-00168 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй  
алтны шороон ордыг ашиглах төслийн  
2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БҮЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### Дэд бүтэц, зам харилцаа

Тус орд газар нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Баянгол болон Булаг голын бэлчир орчим Дархан хотоос зүүн хойш 120 км, Сүхбаатар хотоос зүүн урагш 200 км, Ерөө сумын төвөөс зүүн урагш 30 км, Бугант суурингаас баруун урагш 20 км-д байрлана.

Толгойтын алтны бүлэг ордыг ашиглах үед Бугант тосгон, эмнэлэг, сургууль, 110 кВт-ын цахилгааны өндөр хүчдэлийн шугам, автомашины сайжруулсан зам зэргийг барьж байгуулснаар дэд бүтцийн гол гол асуудлууд бүрэн шийдэгдсэн байдал.

Уурхайд дараах дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлуудыг хийгээд байна. Үүнд: Уурхайд ажилчдын хотхон, цайны газар, амрах байр, дууш саун, оффис, амрах байр, засварын газар зэрэг барилга байгууламжууд, цахилгаан хангамж, ус хангамж, зам талбай зэрэг уурхайн дэд бүтцийг бүрэн шийдсэн. Мөн олборлолтын болон элс угаан баяжуулах цехийн тоног төхөөрөмжүүд, ажиллах хүчинээр бүрэн хангадсан.

### Уур амьсгал

Уур амьсгалын хувьд эх газрын эрс тэс хуурай, халуун бүсэд хамарагдах бөгөөд хоногийн болон жилийн температурын зөрүү эрс өөрчлөлт ихтэй нутаг юм. Хамгийн халуун үе нь 7-8 сард  $+40^{\circ}\text{C}$  (сарын дундаж  $+20^{\circ}\text{C}$ ) хүрэх бөгөөд, 1-р сард  $-35^{\circ}\text{C}$  (сарын дундаж  $-20^{\circ}\text{C}$ ) хүртэл хүйтэргэдэг байна. Салхины дундаж хурд 2.6 м/с, өвөл ба зундаа тогтуун, (0.1-2.3 м/с), хавартаа 35.9 м/с хүртэл ширүүсдэг. Жилд дунджаар 150 мм орчим тунадас унадаг бөгөөд түүний 70% нь зуны улиралд (зөвхөн 7-р сард 258 мм хүрч байсан тохиолдол бий) унадаг

### Усан сүлжээ /Гадаргын ус/

Тухайн районд голын сүлжээ сайн хөгжсөн. Энэ дүүрэгт Ерөө, Бугант зэрэг томоохон голууд байхын зэрэгцээ Толгойт, Нарийн,Өлөнт зэрэг жижиг голууд , уулын ам , газрын гадаргуугийн налууг дагаж нам доор орших уулс хоорондын хөндийн хөрсний усаар тэжээгдэг жижиг горхиуд олонтой.Эдгээр нь дулааны улиралд хур тунадасны усаар 70-80 хувь тэжээл авч хаяар шар усны үеэр түвшин эрс нэмэгдэх ба өвлийн улиралд 0.3-1м хүртэл зузаантай цасан бүрхүүл тогтох жижиг горхинууд ёроолдоо хүртэл хөлдөнө.Зуны улиралын үед голын урсгалын үзүүлэлтүүд нь жилийн улиралаас хамаарч ихээхэн өөрчлөгдөх бөгөөд 2005 онд явуулсан хээрийн судалгааны хэмжилтээр 3.0-6.0 м<sup>3</sup>/с урсацтай , ерөнхий хатуулаг 0.80 мг / дм<sup>3</sup> байсан байна.

### Газрын доорх ус

Газар доорх усны тэжээгдэл нь агаарын хур тунадас, агаарын чийгийн нийлбэрээс бүрдэнэ. Газар доорх усны хамаатуулж тооцох хамгийн том гадаргын усан сүлжээний төлөөлөгч нь Ерөө гол юм. Тэжээгдэл авах цэвдэг , чулуулаг байхгүй учир Ерөө голтой гүний гидравлик холбоотой. Газрын доорх ус нь усны мужийн ангиллаар авч үзвэл ерөө голын ай сав газар нь улирлын дунд зэргийн тэжээлтэйд багтаж байна



Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших MV-00168 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй

алтны шороон ордыг ашиглах төслийн

2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## Хөрс

Судалгааны дүнд 2 хэв шинжийн хөрс байгааг тогтоосон. Хөндийн цайвар хүрэн карбонатлаг хөрс орд газрын уулархаг хэсгийн урд хажуугаар тархжээ. Хар шороон хөрс орд газрын орчин тойронд тархана. Тухайн газрын хөрс нь хотжилт, зам харгуй, газар тариалан, уул уурхайн үйлдвэрлэл зэрэг хүний хүчин зүйлийн хүчтэй нөлөөнд өртөж байгаагүй, зөвхөн малын бэлчээрийн зориулалтаар ашиглагдаж байсан газар юм.

## Ургамал ба амьтны аймаг

Ургамлын бүрхүүл сайн хөгжсөн бөгөөд тал хээрийн бүсийн ургамал тархсан. Хуурай ам хөндийн уулын ойт хээр голын нуга нугажуу газар ба нарс хусан ой, ойн захын энгэр бэл арыг дагасан өвсөн бүрхэвчийг үүсгэгч ургамлын 70 гаруй хувь нь алаг өвс үлдэх хувийг үетэн улалж болон бусад ургамал бүрдүүлж байна. Амьтны аймгийн төрөл зүйлийн хувьд цөөхөн төрөл зүйл, цөөхөн тоо толгойтой байдаг. Гол төлөв нүүдлийн туурайтан болон мэрэгчид, шувууд энд нутагладаг. Манай орны бусад уулархаг нутагтай харьцуулахад экологийн хувьд нэгэн жигд, цөөвтөр зүйлийн бүрэлдэхүүнтэй, тоо толгойн хувьд нягтшил ихтэй бүс нутагт хамаарна.

## Геологийн тогтоц

Хандгайтын уурхай нь геоморфологийн ангиллаар Хэнтийн уулархаг мужийн бага ба Их Хэнтийн нурууны өндөр уулын районд багтах учир уулсын хамгийн өндөрлөг газрууд буюу уул зүйн дээд давхаргад хамаардаг нутаг юм. Уулсын үнэмлэхүйн өндөр 2500-2800м, харьцангуй өндөр нь 1000м-с их байна. Уулсын хооронд их хөгжсөн голуудын усан сүлжээтэй хөндийн ёроол нь харьцангуй өндөрөөс ихэд доошилсон онцлогтой. Энэ орчмын уулс тектоникийн цулдам хөдөлгөөнөөр бүрэлдэн тогтсон бөгөөд дөрөвдөгч галавын эртний мөстлөгийн нөлөөгөөр элэгдсэнээс гадна орой нь тэгширч хавтгай буюу бөмбөгөрдүү болсон байдаг.

## ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ

### ТОДОРХОЙЛОЛТ

#### Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл

Ил уурхайн уурхайлалтын явцад гарах хөрс зөөх, элс ачих бүхий л үйлдвэрийн шатанд үүсэх бага хэмжээний тоосжилт нь орчны агаарыг бохирдуулах эх үүсвэр болох юм. Мөн хүдрийн овоолгын болон хаягдал чулуулгийн овоолгын гадаргаас салхины элэгдлээр бага хэмжээний тоосжилт үүснэ.

#### Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл /хөрсний элэгдэл, эвдрэл/

Барилга байгууламж барих үеийн болон барьсны дараах хөрсний эвдрэл, машин механизмын засвар үйлчилгээний явцад гарах шатах тослох материалын асгаралт зэргээс хөрсний бохирдол үүсэх үүсвэрүүд болж болзошгүй.



Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших MV-00168 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй

алтны шороон ордыг ашиглах төслийн

2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### ***Ургамал амьтанд үзүүлэх нөлөөлөл***

Үйл ажиллагааны явцад хөрс хуулалт, элс тээвэрлэлт, ажил ихээр хийгдэж, ургамлан нөмрөг устаж, тус газарт нутагшсан жижиг мэргч амьтдын амьдрах орчин алдагдана. Ургамлан нөмрөг /ой мод өртөгдсөнөөс/ их хэмжээгээр устсанаас тухайн орчны агаарын экосистемд өөрчлөлт бий болно. Уурхайн эдэлбэр газар, дэд бүтцийн ажил хийгдвэл тухайн өртөгдөх газрын ургамал, амьтан өртөх магадлалтай.

### ***Газрын хэвлийд үзүүлэх нөлөөлөл***

Уурхайлалтын үйл ажиллагааны үед хөрс хуулалт их хэмжээгээр явагдаж, газрын хэвллийд хонхор үүсгэж, гүнээс гарах бага хэмжээний хөрсний овоолго газрын хэвлий дээр бий болон газрын ландшафтад өөрчлөлт бий болно.



Хүснэгт-3. Байгал орчинд нөлөөлөх нөлөөлөл түүний эрчим

Д.Д	Байгаль орчны бүрдэл хэсгүүд	Нөлөөлөл			Хугацаа		Давталт		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Ургт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалгүй нөлөөлөх	Бага	Дунд	Хүйтэй
	<i>Агаар орчинд үзүүлэх нөлөөлөл</i>										
	Үйлдвэрлэлийн явцад гарах тоос орчинд тархаж агаарын чанарын стандартаас давах	+			+		+			+	
	Тоосжилт ургамал, амьтан, ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх байдал		+		+		+			+	
	Ахуйн хаягдал, хогийн ариутгал зайлцуулалт муугаас эвгүй үнэр гарах			+	+		+		+		
	Тээврийн хэрэгсэл, техникийн яндангаас хаягдах утаа бус нутгийн агаарын чанарт сөргөөр нөлөөлөх эсэх			+			+		+		
	Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий гардаг эсэх										
	<i>Хөрсний бохирдол, элэгдэл эвдрэлээс гарах нөлөөлөл</i>										
	Хөрс ахуйн хогоор бохирдох			+	+			+	+		
	Ил уурхайн ухааш, овоолго үүсгэн газрын гадрагын хэлбэр дүрсийг өөрчлөх	+				+		+		+	
	Ахуйн бохир ус нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс бохирдуулах байдал	+			+			+	+		
	Шороон зам харилцаа, машин механизмын хөдөлгөөн шилжилтээс гарах хөрсний эвдрэл			+	+				+		
	Барилга байгууламж барих үсийн болон барьсны дараах хөрсний элэгдэл, эвдрэл		+		+		+		+		
	<i>Ургамалын аймагт үзүүлэх нөлөөлөл</i>										
	Ой модыг огтлох гэмтээх асуудал	+			+			+	+	+	
	Уурхайн үйл ажиллагаа болон технологийн замын өөрчлөлтөөс тодорхой талбайн ургамал устаж дарагдах	+				+	+			+	



Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших MV-00168 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон ордыг ашиглах төслийн  
2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Амьтаны аймагт үзүүлэх нөлөөлөл									
	Ан амьтан агнах хороох, хавх урхи тавих оролдлого ихсэх			+	+		+		+
	Хөхтөн амьтан болон мэрэгчдийн амьдрах орчин хязгаарлагдах	+				+		+	+
	Амьтдын нүүдэл, гүйдлийн замуудад саад учрах		+			+	+		+
Дуу чимээнээс орчны экосистемд үзүүлэх нөлөөлөл									
	Амьтад орчны дуу чимээнээс дайжих			+	+		+		+
Газрын хэвлийд үзүүлэх нөлөөлөл									
	Уурхайлалтын үйл ажиллагааны үед хөрс хуулалт их хэмжээгээр явагдаж, газрын хэвлийд хонхор үүсгэж, гүнээс гарах их хэмжээний хөрсний овоолго газрын хэвлий дээр бий болон газрын ландшафтад өөрчлөлт бий болно.	+				+		+	+

## **ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ**

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө /БОМТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Ди Зэт Энд Ай” ХХК -аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, БОАЖЯ -аас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагын дагуу боловсруулсан болно.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээгээр тавигдсан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд бөгөөд түүнтэй холбогдон гарага бусад зураг төслийн буюу туслах чанарын ажлуудын зардал ороогүй.

Энэхүү төлөвлөгөөнд тусгасан байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүд нь зөвхөн “Ди Зэт Энд Ай” ХХК -аас Толгойтын алтны шороон ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэхэд зориулагдсан болно.

БОМТ -ний ихэнх хэсэг Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөртэй нягт уялдах бөгөөд төслийн хэрэгжилтийн бүхий л хугацааны туршид газрын доорх ус, агаар, хөрсний чанар, ургамалжилт, амьтны аймагт гарч байгаа өөрчлөлтүүдийг тухай бүрт нь шинжилж, холбогдох арга хэмжээг жил бүрийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлнэ.

БОХТ -ний хэрэгжилтийн талаарх тухайн жилийн хяналт, үзлэгээр төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр, түүний ойр орчмын нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд дүгнэлт хийх ажлыг байгаль орчны хяналт шинжилгээний ажлын үр дүнгүүдэд үндэслэн хийнэ.

“Ди Зэт Энд Ай” ХХК-ний 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 дугаар журмын дагуу боловсрууллаа.



## ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт-5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.*

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Үрьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
<b>1.АГААР ОРЧИН</b>							
1.	Цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдэл	Цаг уурын урьдчилан сэргийлэх мэдээг үйл ажиллагаанд тогтмол ашиглах	Уурхайн бүхий л үйл ажиллагаанд		150.0	Төсөл хэрэгжих хугацаанд	Aгаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2.	Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Агаар бохирдуулагч эх Үүсвэрүүдэд агаарын тоосжилтын хэмжилтийг шинжлүүлэх /TSP, PM 10, PM 2.5/	-Хөрсний овоолго -Ухаш -Тээврийн зам	ОХШХ-т тусгав.	5, 7, 9-р сард		Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998
3.		Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэх/SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> /	-Хөрсний овоолго -Ухаш -Тээврийн зам	ОХШХ-т тусгав	5, 7, 9-р сард		MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй.
4.		Дотоод болон гадаад тээвэрлэлтийн замыг тогтмол услах	Гадаад дотоод тээврийн зам	УАЗ	Төсөл хэрэгжих хугацаанд		Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
5.		Зам талбайг техник хэрэгсэлд тохиромжтой байдлаар засч дагтаршуулах	Гадаад, дотоод тээврийн зам	УАЗ	Төсөл хэрэгжих хугацаанд		MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ
	<b>Дүн</b>			<b>150.000</b>			
<b>2.ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСОН БҮРХЭВЧ</b>							



Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших MV-00168 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон ордыг ашиглах төслийн  
2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

6.	Газрын гадарга эвдэрч, Хөрсний үржил шим алдагдах, бохирдох, эвдрэх, доройтох	Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж хадгалах	Үйл ажиллагаа эхлэх үед, шинэ газар хөндөх бүрт		<b>1.000.0</b>	Төсөл хэрэгжих хугацаанд	Хөрс хамгаалах Цөлжилтөөс сэргийлэх тухай хууль Газрын тухай хуулийн 50.1.1 MNS5914:2008, “Газар шорооны ажлын үсийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” MNS4919:2000, “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага” “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал	
7.		Авто тээврийн хэрэгслийг тогтсон машрутаар зорчих, олон салаа зам гаргахгүй байх, замыг тэмдэгжүүлэх	Уурхай хэмжээнд		<b>100.0</b>	Тогтмол		
8.		Хөрсний хяналтын цэгүүдийг уурхайн нөлөөллийн бүсийн хэв шинжээс хамаарч байгуулах			<b>200.0</b>			
		<b>Дүн</b>		<b>1300.0</b>				
<b>3. ГАДАРГЫН ДООРХ УС</b>								
9.	Үнд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар усыг хэмжээгээр ашигласнаар усны нөөцдөд сергөөр нөлөөлөх	Ус ашиглах дүгнэлтийг “Усны газар”-аар гаргуулж ажиллах	Уурхайн талбайн хэмжээнд		<b>845.000</b>	Төсөл хэрэгжих хугацаанд	Усны тухай хууль: Зүйл 24-1.1, 1.2; Зүйл 30; Зүйл 31-1, 2, 3, 4, 5, 6, 8; Зүйл 33-1, 2, 3; Зүйл 34- 1, 2; Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” MNS4596:1998.	
10.		Ус ашигласны төлбөр төлөх	Төслийн талбайн хэмжээнд		Ашигласан усны хэмжээгээр	Төсөл хэрэгжих хугацаанд	БОНБНУ, Компанийн дотоод журам, Усны менежментийн төлөвлөгөө	
11.		Тунгаагуур нуурууд болон уурхайн үнд ахуйд хэрэглэж	Төслийн талбайн хэмжээнд		<b>ҮАЗ</b>	Тогтмол		



Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших MV-00168 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон ордыг ашиглах төслийн  
2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	Газрын доорх ус	буй усны эх үүсвэрүүд зэргээс тогтмол хугацаанд дээж авч бохирдолыг хянан ажиллах замаар сөрөн нөлөөллөөс урьдчилан сэргийлэх				
		<b>Дүн</b>	<b>845.0</b>			
<b>АМЬТНЫ АЙМАГ</b>						
13.	Уурхайн үйл ажиллагааны улмаас амьтдын амьдрах орчин хумигдах, хүн болон автомашины хөл хөдөлгөөн, дуу чимээнээс амьтад дайжих	Лицензтэй талбай болон Дүйцүүлэн хамгааллын талбайн зэрлэг амьтан, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан амьтдын судлагаа хийж мэдээллийн сан үүсгэж ажиллах Ерөө сумын ЗДТГазар болон Байгаль орчны албанаас зөвлөгөө авах	Төслийн талбайн ойр орчим, Дүйцүүлэн хамгааллын талбай	Дүйцүүлэн хамгааллын зардалд тусгав.	Төсөл хэрэгжих хугацаанд	Амьтны тухай хууль
<b>УРГАМЛАН НӨМРӨГ</b>						
14.		Ургамалын мониторингийн цэгийн хэмжилт хяналт, мэдээллийн сан үүсгэж ажиллах	Уурхай хэмжээнд	1000.0	Төсөл хэрэгжих хугацаанд	
		<b>Нийт дүн</b>	<b>3245.0</b>			

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших MV-00168 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон ордыг ашиглах төслийн  
2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Техникийн нөхөн сэргээлт	‘Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ’ зорилтын хүрээнд 2 га талбайг нөхөн сэргээж орон нутгийн мэргэжлийн байгууллагт хүлээлгэж өгөх	га	8.5	-	9.000.0	8-10cap	MNS 5917:2008
2	Биологийн нөхөн сэргээлт	Уурхайн тоосжилтын бууруулж, мод, бут тарих, зүлэгжүүлэх	га	0.5		500.0	5-6 cap	MNS 6258-1 : 2011
3	Тэрбум мод тарих хөтөлбрүйн хүрээнд хэрэгжүүлэх		га	0.5		950		
<b>Нийт</b>				<b>10 000.0</b>		<b>10 000.0</b>		

### ДОЛОО. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Монгол улсын засгийн газрын 2020-2024 онд хийж	Сэлэнгэ аймгийн хэмжээнд уул уурхайн улмаас эвдэрч олон жил орхигдсон нөхөн сэргээлт хийгдээгүй талбайд	га	4	-	5 000,0	Төлөвлөгөөт онд	Сэлэнгэ аймгийн БОАЖГазрын 2023 оны 4-р сарын 20 өдрийн №239



Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших MV-00168 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон ордыг ашиглах төслийн  
2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	гүйцэтгэх 8000 га нөхөн сэргээлт хийх	техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэнэ.						дугаартай албан тоот
	<b>Нийт</b>					<b>5 000,0</b>		

### НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн MV-0168 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд зайлшгүй нүүлгэн шилжүүлэх шаардлагатай асуудал байхгүй байна.

### ЕС. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжих уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохицын байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

### АРАВ. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сорог иолоолол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаах дүрэм, журам боловсруулж мөрдлөг болгон ажиллах	Нийт ажилчид	-	ҮАЗ	ҮАЗ	Үйл ажиллагааны турш	Аюулгүй байдал ба уян хатан байдал онцгой байдлын удирдлага осол аваарын үеийн менежментийн удирдамж MNS: 22300:2020,
2		Бүх ажилчдыг гал түймэр унтраах мэргэжлийн сургалтад хамруулах	Нийт ажилчид	-	-	300.0		

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших MV-00168 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон ордыг ашиглах төслийн  
2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3		Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байршуулах, гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах	Нийт ажилчид	-	ҮАЗ	ҮАЗ	Үйл ажиллагааны турш	Компанийн онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөө
4			Төслийн хэмжээнд	-	-	-	Үйл ажиллагааны турш	
5	Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс машин техникийд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх гэх мэт осол аваар гарах	Анхааруулга, замын таних тэмдэг тэмдэглэгээг уурхайн талбай болон шаардлагатай газруудад байрлуулах	Төслийн хэмжээнд	-	-	200.0	Үйл ажиллагааны турш	
6			Төслийн хэмжээнд	-	-	-	Үйл ажиллагааны турш	
	<b>Нийт</b>					500.0		

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших MV-00168 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон ордыг ашиглах төслийн  
2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### АРВАННЭГ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, сая.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Үйлдвэр, Ахуйн хаягдал	Хог хаягдлыг тогтсон нэг цэгт төвлөрүүлж, ангилан ялгах, ариутгах зайлзуулах	Түр хогийн цэг	-	-	-	300.0	Төсөл хэрэгжих хугацаанд	
2.		Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин боловсруулалт хийх зорилгоор ангилан ялгалтын хогын сав байршуулах	ХБҮ, Уурхайн суурин	-	-	3	2000.0	Төсөл хэрэгжих хугацаанд	
3.		Ил задгай хог хаяхгүй байх талаар анхааруулга санамж бүхий самбарыг шаардлагатай цэгт байршуулах	Уурхай хэмжээнд	III	-		100.0	Төсөл хэрэгжих хугацаанд	
	Нийт						2400.0		

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших MV-00168 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон ордыг ашиглах төслийн  
2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### АРВАНХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
1	Агаар – Тоосжилт PM(2.5), PM(10), NO <sub>2</sub> , SO <sub>2</sub>	- Тээврийн зам - Засварын талбай			50.0	200.0	-	MNS 4585:2016
2	Хөрс – Нефтийн бүтээгдэхүүн, Агрехимий	- Засварын талбай - Тусгай зөвшөөрлийн талбайд - Шимт хөрсний овоолго	6, 9 сар	2 удаа	50.0	300.0	-	MNS 5850:2008 Хөрсөнд агуулагдах организ биш бохирдуулагч бодисын хүлцэх хэмжээ
3	Ус – Ерөнхий хими	- Унд ахуйн худгийн ус			50.0	200.0	-	MNS 900:2005 MNS 4586:98
	Нийт					700.0		

### АРВАНГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Үрьдчилан тооцсон төсөв /сая.төг/	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар		
			2023. он						
			Cap ...	Cap ...	Cap ...				
1	1	2	3	4	5	6	7		
1	Уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд дотоод хяналтын тогтолцоог нэвтрүүлэн зөрчил дутагдлыг илрүүлэн арилгах,	ҮАЗ	Төсөл хэрэгжих хугацаанд			Уурхайн удирдлагууд	-		



Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших MV-00168 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон ордыг ашиглах төслийн  
2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх				
2	Байгаль орчны мэргэжилтнийг нэмэгдүүлэх	-	Төлөвлөгөөт онд		-
3	Хог ангилан ялгах тухай журам боловсруулан, сургалт зохион байгуулах	-	Төлөвлөгөөт онд	БОИнженер, Уурхайн нийт ажилчид	
4	Асгарсан бодисыг саармагжуулах журам боловсруулах	-	Төлөвлөгөөт онд	БОИнженер	
5	Байгаль орчны салбарын тэмдэглэлт өдрүүдээр үйл ажиллагаа зохион байгуулах, мэдлэг олгох	-	Төлөвлөгөөт онд	БОИнженер, Уурхайн нийт ажилчид	
6	Хууль бусаар амьтан агнах, ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээвэрлэх, ашиглахыг хориглох тухай нийт ажилтануудад сургалт зохион байгуулах	-	Төлөвлөгөөт онд	БОИнженер, Уурхайн нийт ажилчид	
7	Хуурайшилтын үед ой хээрийн түймрээс сэргийлж сургалт зохион байгуулж зурагт хуудас тараах	<b>500.0</b>	Төлөвлөгөөт онд	БОИнженер, Уурхайн нийт ажилчид	
	<b>Нийт</b>	<b>500.0</b>			



Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших MV-00168 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон ордыг ашиглах төслийн  
2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**АРВАНДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН  
БУСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	БОМТ-ний биелэлтийг тайлagnахад оролцогч талууд	Тайлagnах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлagnах зардал, сая.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1	БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	Тухайн жилийн БОМТ , тайлан	Сургалтын чиглэлээр	Тухай бүрт	ҮАЗ	Урхайн дарга, БОИнженер	Сэлэнгэ аймаг Ерөө сум, Бугант тосгон
2	Урхайн үйл ажиллагааны талаар нутгийн иргэд болон олон нийттэй санал солилцох, хэлэлцүүлэг зохион байгуулах	Аман болон бичгээр	Төслийн талаархи	6-8 сар	1.0		
3	Нөхөн сэргээлт хийсэн болон тайлан төлөвлөгөөг орон нутгийн мэргэжлийн байгууллагад хугацаанд нь тайлagnах, хүлээлгэж өгөх	Бичгээр	Нөхөн сэргээлтийн акт	9-10 сар	ҮАЗ		Сэлэнгэ аймаг БОАЖГ, Ерөө сум Бугант тосгон
	<b>Нийт</b>				<b>1.0</b>		



# БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ

## ЗАРДЛЫН ЗАДАРГАА /2023 ОН/

*Хүснэгт-11. Зардлын задаргаа.*

Д.Д	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Зардал мян/төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Төслийн талбай	14	3245.0
2	Нөхөн сэргээлт		2	10 000.0
3	Дүйцүүлэн хамгаалал		1	5 000.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох		-	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах		-	-
6	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө		6	500.0
7	Хог хаягдлын менежмент		3	2 400.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр		3	700.0
9	Удирдлага зохион байгуулалт		7	500.0
10	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах		3	1 000.0
	<b>Нийт</b>		<b>39</b>	<b>23 345</b>





СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг,  
Утас/Факс: (976)-7036-3653

“ДИ ЗЭТ ЭНД АЙ” ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ Т.ДАРАМДОРЖ-Д

2023.04.20 № 239  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Санал хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар хэсгийн 5.1.8-д “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8000 га талбайг нөхөн сэргээнэ” гэсэн зорилт тусгагдсан.

Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн зорилтыг үндэслэн Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын хамтарсан 2020 оны “Нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай” 167, А/698, А/336, А/242 тоот тушаалаар батлагдсан “Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээ хэрэгжиж байна.

Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд БОАЖСайдаас ирүүлсэн албан бичигт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын жил бурийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд тодорхой хэмжээ бүхий эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг хийлгүүлэх талаар тусган хэрэгжилтийг хангуулахаар заасан.

Дээрх зорилт, чиглэлийн хүрээнд Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт эвдэрч олон жил орхигдсон нөхөн сэргээлт хийгээгүй талбайгаас тодорхой хэмжээ бүхий талбайн нөхөн сэргээлтийг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд төлөвлөн гүйцэтгүүлэхээр газарзүйн солбицлыг тодорхой зааж албажуулан ажиллаж байна.

Иймд MV-000168 тоот тусгай зөвшөөрөлтэй танай компани Ерөө сумын 3-р багийн нутаг дэвсгэр Их Өлөнтийн ам нэртэй газрын

49 24 57.51 107 22 19.64

49 24 46.46 107 22 8.19

49 24 48.43 107 22 4.18

49 24 59.53 107 22 16.08 солбицол бүхий эвдрэлд орж эзэнгүй орхигдсон 4 га талбайн солбицол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар хэрэгжиж буй “Тэрбум” үндэсний хөдөлгөөний хүрээнд ойг нөхөн сэргээх, ойжуулах ажлыг тус тус 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган батлуулж, холбогдох журам, стандартын дагуу нөхөн сэргээлт хийж хамтран ажиллана уу.

Жич: БОАЖСайдын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 02 дугаар албан даалгаврын 4 дэх хэсэгт заасны дагуу хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор био болон боловсон 00 бий болгох шаардлагатай.